



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/11

Номгон

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх
үндэсний хөтөлбөр”-ийг 2022 онд хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 7.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 6,0 сая (Зургаан сая) төгрөгийг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

601220023

Аймгийн Засаг даргын-ны дүгээр сарын
 07-ны өдрийн дүгээр захирамжийн хавсралт



**БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
 АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго		Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ.				
Үр нөлөө		Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн эрх зүйн ухамсар дээшилнэ.				
№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсөв
1	2	3	4	5	6	7
Зорилт Нэг. Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.						
1.1	Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран зорилтот бүлгийн иргэдэд хуулийн мэдлэг олгох эрх зүйн анхан шатны сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл өгөх	Сургалтыг 100 иргэнд зохион зохион байгуулж эрх зүйн зөвлөгөө өгснөөр	Жилийн турш	Хууль зүйн туслалцааны төв	Хууль, эрх зүйн хэлтэс	300.0
Зорилт Хоёр. Шаардлагатай техник, санхүү, хүний нөөцийг бүрдүүлж, тогтсон мэдээллийн сувгуудыг бий болгон тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.						
2.1	Гэмт хэрэг ихээр гардаг сумдын багуудын Иргэдийн нийтийн хуралд дээр тусгай төлөвлөгөөний дагуу соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцох	Төлөвлөгөөний биелэлтийн хувиар	Жилийн турш	Хууль зүйн туслалцааны төв	Хууль, эрх зүйн хэлтэс	600.0

1	2	3	4	5	6	7
2.2	Сумдын эрх зүйн ажлыг сайжруулах зорилгоор "Хуулиа дээдэлье" болзолт уралдааныг зохион байгуулж үр дүнг тооцох	Болзолт уралдааныг зохион байгуулж, үр дүнг тооцсоноор	Жилийн турш	Хууль зүйн туслалцааны төв	Хууль, эрх зүйн хэлтэс	2.5
2.3	Шинээр байгуулагдсан "Эрх зүйн хөтчийн булан"-г иргэдэд сурталчлах.	Иргэдийн эрх зүйн мэдээлэл авах боломж бүрэн бүрдсэнээр	Хагас жилд	Хууль, эрх зүйн хэлтэс	Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба, ТВ9 телевизийн аймаг дахь ажилтантай хамтран	-
Зорилт Гурав. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд нийгмийн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.						
3.1	Эрх зүйн хөтөч нарыг хууль тогтоомжийн эмхтгэл гарын авлагаар хангах	Гарын авлагаар хангаснаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд	2.0
3.2.	MGL радиотой хамтран эрх зүйн боловсрол олгох соён гэгээрүүлэх мэдээ, мэдээллүүдийг хүргэх	Мэдээ мэдээллийг 2 -оос доошгүй удаа хүргэснээр	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд	500.0
3.3.	Эрх зүйн хөтчийг давтан сургах ажлыг зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан эрх зүйн хөтчийн тоо	2-р улиралд	Хууль, эрх зүйн хэлтэс	ХЗДХЯ, ХЗҮХ	1.0
3.4.	Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарын судалгааг шинэчлэн боловсруулж, тэдэнд чиглэсэн сургалтын тусгай төлөвлөгөөг аймгийн Нотариатын танхимтай хамтран батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 -ээс дээш хувьтай хангаж ажилласнаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Аймгийн нотариатчид	-
3.5.	Сум, байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус захиалгат сургалтыг тухай бүр зохион байгуулах.	2000 иргэд, төрийн албан хаагчийг хамруулснаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Байгууллагуудын Эрх зүйн хөтөч, сумдын	-

1	2	3	4	5	6	7
3.6.	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар видео сургалт бэлтгэж олон нийтэд түгээх	Сургалтыг видео хэлбэрээр хийж олон нийтэд түгээсэн байна	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Аймгийн ИТХ	-
3.7.	Хөдөлмөрийн тухай хуулийн хамтын гэрээ, байгууллагын дотоод журам, ажил амралтын цаг, сахилгын шийтгэл, хөдөлмөрийн гэрээ сэдвүүдийн хүрээнд тусгай хуваарийн дагуу төсөвт байгууллагуудын удирдлагууд, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад цахим болон танхимын сургалт зохион байгуулах	Сургалтуудыг зохион байгуулснаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд, Үйлдвэрчний эвлэл, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран	-
3.8.	Иргэдэд зах зээлд шударгаар өрсөлдөх талаар мэдлэг олгох гарын авлага бэлтгэн хүргэх	Гарын авлагыг бэлтгэж иргэдэд хүргэснээр	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	500.0
3.9.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулснаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	500.0
3.10	Хуванцар савны тэмдэг тэмдэглэгээг иргэд, хэрэглэгчдэд зөв ашиглах талаар цахим мэдээллийн хэрэгслээр сурталчлах	Сурталчилгааг хийснээр	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	-
3.11	Эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшил,	Судалгааг хийснээр	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	ТББ-ыг оролцуулах	-

1	2	3	4	5	6	7
	иргэдийн оролцоог хангах					
3.12	Иргэдэд эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор иргэн иргэндээ мэдээлэл өгдөг зөв мэдээллийн сүлжээ байгуулах	Эрх зүйн мэдээ мэдээллийг иргэдээр дамжуулан иргэдэд хүргэснээр	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтэс, иргэдийн төлөөлөл	100.0
3.13	“Хүүхдийн хүмүүжил хөгжил хамгаалалд” нэрлэсэн жилийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдад “Өсвөр насны хүүхдийн анхаарах асуудал” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж, зөвлөмж өгөх	Сургалтыг зохион байгуулж зөвлөмжийг өгснөөр	1 дүгээр улиралд	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	-
3.14	Ерөнхий боловсролын болон хүүхдийн өөрөө удирдах байгууллагын гишүүн хүүхдүүдэд “Ялгаварлан гадуурхалт ба дээрэлхэлт” сэдвээр сургалт зохион байгуулах	Сургалтыг зохион байгуулж зөвлөмж өгч ажилласнаар	Жилдээ	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	-
3.15	Эрх зүйн хөтөч нарт эрх зүйн мэдлэг олгох цахим сургалт зохион байгуулах	Цахим сургалтыг зохион байгуулснаар	1 дүгээр улиралд	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд	-